

2020 11.1  
№179

## Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8.1.14 дүгээр заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журам”-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн газар /Ө.Сүхбаатар/-т даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны “Журам шинэчлэн батлах тухай” 172 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР

## **ШИНЖЛЭХ УХААНЫ ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Шинжлэх ухааны салбарт тухайн онд бүтээгдсэн шилдэг бүтээлийг шалгаруулах, шагнах, дэмжлэг үзүүлэх үндсэн зарчмыг тогтоох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шинжлэх ухааны шилдэг бүтээлд дараах бүтээлийг хамруулна. Үүнд:

- Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, онолын өндөр түвшинд хийгдсэн судалгааны ажлын үр дүнг боловсруулан туурвисан ном, зохиол /сурах бичиг хамаарахгүй/
- Судалгааны үр дүнд бий болсон технологи, биет бүтээгдэхүүн

1.3. Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан шинжлэх ухааны оны шилдэг бүтээлийг шалгаруулж, шагнал олгоно.

### **Хоёр. Шинжлэх ухааны шилдэг бүтээлд дэвшүүлэх**

2.1. Эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, эрдэмтдийн хамтлаг, хувь хүмүүс шинжлэх ухааны бүтээлээ оны шилдэг бүтээлд дэвшүүлж болно.

2.2. Шилдэг бүтээлд зөвхөн тухайн онд гарсан бүтээлийг дэвшүүлнэ.

2.3. Дэвшүүлэх бүтээлийг дараах баримт бичгийн хамт шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор байгууллагын албан бичгийн хамт ирүүлнэ. Үүнд:

- Бүтээл болон түүний зохиогчийн товч танилцуулга,
- Бүтээлийн онол, практикийн ач холбогдлыг хэлэлцэн шинжлэх ухааны шилдэг бүтээлд дэвшүүлэхээр шийдвэрлэсэн эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр,
- Бүтээлийг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын үнэлгээ, мэргэжлийн дүгнэлт буюу нэвтрүүлж ашиглах талаар хийсэн гэрээ, хэлцэл,
- Шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ зэрэг зохиогчийг гэрчлэх баримтууд.

2.4. Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлд шалгарсан бүтээлийн материалыг буцааж олгохгүй. Шалгараагүй бүтээлийн материалыг буцаан олгож болно.

## **Гурав. Шилдэг бүтээлийг шалгаруулах**

3.1. Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлд дэвшүүлсэн бүтээлүүдэд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах эрдэмтдийн бүрэлдэхүүн бүхий шинжээчийн хэсгийг Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийн шийдвэрээр байгуулна.

3.2. Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлд бүтээлээ дэвшүүлсэн эрдэмтэн, судлаачийг шинжээчийн хэсгийн гишүүнээр томилохгүй.

3.3. Шилдэг бүтээл шалгаруулах шинжээчийн хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна. Нийт гишүүдийн 80 хувь нь ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.4. Шагналд дэвшигч бүтээлээ шинжээчийн хэсгийн хуралдаанд биечлэн танилцуулна.

3.5. Шилдэг бүтээлийг дараах үзүүлэлтээр шалгаруулна:

- Бүтээлийн шинжлэх ухааны салбарт оруулж буй хувь нэмэр, ач холбогдол,
- Тухайн бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн байдал,
- Үйлдвэрлэл, үйлчилгээ, бусад салбарт нэвтрүүлэх боломж, практик хэрэглээ болгосон байдал, гарсан үр дүн

3.6. Шинжээч нь бүтээл тус бүрт энэ журмын 3.6 дахь хэсэгт заасан үзүүлэлтээр журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу 1-5 онооны үнэлгээ өгнө.

3.7. Шинжээчдийн өгсөн оноог энэхүү журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу нэгтгэж, онооны нийлбэрээр хамгийн өндөр үнэлгээ авсан бүтээлээс эхлэн шагналд дэвших бүтээлийг байр эзлүүлнэ.

3.8. Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлийг шалгаруулах шинжээчийн хэсгийн хуралдаанаар тухайн жилд шалгаруулалтад ирсэн бүтээлүүдийн тоо, чанараас хамааруулан нэгдүгээр байрын шагналыг нэг, хоёрдугаар байрын шагналыг хоёр, гуравдугаар байрын шагналыг гурав, тусгай шагналыг дөрөв хүртэл бүтээлд олгож болно.

## **Дөрөв. Шилдэг бүтээлийг шагнах**

4.1. Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлийн шалгаруулалтын дүнг Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталгаажуулна.

4.2. Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлд өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

4.3. Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлийн нэгдүгээр байрт дөрвөн сая, хоёрдугаар байрт гурван сая, гуравдугаар байрт хоёр сая, тусгай байрт нэг сая төгрөгийн мөнгөн шагнал тус бүр олгоно.

4.4. Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах шинжээчийн хэсгийн үйл ажиллагааны зардал болон оны шилдэг бүтээлд олгох өргөмжлөл, мөнгөн шагналыг

Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлнэ. Шагналын сангийн хэмжээ жилд 20 /хорин/ сая төгрөгөөс доошгүй байна.

### **Тав. Шилдэг бүтээлд дэмжлэг үзүүлэх**

5.1. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шинжлэх ухааны оны шилдэг бүтээлээр шалгарсан бүтээлд дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлж болно:

5.1.1. Бүтээлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх байгууллагатай хамтран инновацийн төсөл хэрэгжүүлэх;

5.1.2. Бүтээлийн зохиогчид зохих журмын дагуу зэхэц ажлын санхүүжилт олгох.

---oOo---

Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл  
шалгаруулах журмын нэгдүгээр хавсралт

Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлд дэвшсэн  
бүтээлд өгөх үнэлгээ

№	Бүтээлийн нэр	Дүгнэх үзүүлэлт			Үнэлгээний нийт оноо
		Шинжлэх ухааны салбарт оруулж буй хувь нэмэр, ач холбогдол	Тухайн бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн байдал	Үйлдвэрлэл, үйлчилгээ, бусад салбарт нэвтрүүлэх боломж, практик хэрэглээ болгосон байдал, гарсан үр дүн	
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
...					

Шинжээчийн гарын үсэг ..... /дугаар/

..... он ..... сар ..... өдөр

Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл  
шалгаруулах журмын хоёрдугаар хавсралт

**Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлд дэвшсэн бүтээлийн үнэлгээний нэгдсэн дүн,  
бүтээлийн эзэлсэн байр**

№	Бүтээлийн нэр	Шинжээч нэг бүрийн бүтээлд өгсөн үнэлгээний нийт оноо												Үнэлгээний нэгдсэн дүн	Байр		
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			...	
1																	
2																	
3																	
4																	
5																	
6																	
7																	
8																	
9																	
10																	
11																	
12																	
13																	
14																	
15																	
...																	
Шинжээчийн гарын үсэг																	

..... он ..... сар ..... өдөр